



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дэлүүн сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2022/64/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Өлгий хот 2022 он</p>	<p>Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган Утас:70422954 Цахим хаяг: Khuanganm@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг:jenisbekh@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Д.Назгүл Утас:99427301 Цахим хаяг: nazguld@audit.gov.mn</p> <p>Уужим Алтай Аудит ХХК-ны аудитор: Х.Айгерим Утас:94911004 Цахим хаяг: aykonkh1005@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал, дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
3.Аудитын тайлан.....	14
3.1 Ерөнхий зүйл.....	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Материаллаг байдал	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл,нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	18
3.8 Аудитын гол асуудал	18
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
4. Аудитын илрүүлэлт	19
4.1 Залруулсан алдаа	19
4.2 Төлбөрийн акт	19
4.3 Албан шаардлага	19
4.4 Зөвлөмж.....	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20

Товчилсонүгийнжагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

1. Аудитын санал, дүгнэлт

 БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 83129 Өлгий, Баян-Өлгий аймаг, Утас/Факс: (976) 7042-2954 E-mail: bayanulgii@audit.gov.mn	ДЭЛҮҮН СУМЫН ХҮҮХДИЙН 1 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ Х.АМАНГУЛ ТАНАА
<p>2022-02-17 № 94 танай _____-ны № _____-т</p>	
АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ	
Зөрчилгүй дүгнэлт	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дэлүүн сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.</p>	
<p>Дэлүүн сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.</p>	
Дүгнэлтийн үндэслэл	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.</p>	
Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага	
<p>Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.</p>	
<p>Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.</p>	
Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага	
<p>Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.</p>	

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>67,853,715.44</u>	<u>78,109,156.44</u>
33	АВЛАГА	-	15,000,000.00
335	Бусад авлага	-	15,000,000.00
3351	Байгууллагаас авах авлага	-	15,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	67,853,715.44	63,109,156.44
354	Хангамжийн материал	67,853,715.44	63,109,156.44
35420	Аж ахуйн материал	110,000.00	-
35440	Түлш, шатах тослох материал	2,829,000.00	6,525,000.00
35460	Хүнсний материал	6,997,967.00	5,831,728.00
35470	Бусад хангамжийн материал	57,916,748.44	50,752,428.44
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>823,933,344.73</u>	<u>809,106,836.68</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	823,933,344.73	809,106,836.68
392	Биет хөрөнгө	816,733,344.73	801,906,836.68
39201	Барилга, байгууламж, орон сууц	825489545.00	825489545.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(35,648,266.56)	(45,004,777.62)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	22,760,200.00	24,112,700.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(16,827,450.21)	(18,505,635.13)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	22,188,170.00	22,303,170.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(16,591,521.74)	(17,741,676.29)
39214	Бусад үндсэн хөрөнгө	29173265.42	29173265.42
39215	Хуримтлагдсан элэгдэл	(17,126,533.18)	(21,361,290.70)
39217	Ном	3,315,936.00	3,441,536.00
393	Биет бус хөрөнгө	7200000.00	7200000.00
39301	Програм хангамж	550000.00	550000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-550000.00	-550000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	7200000.00	7200000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>891,787,060.17</u>	<u>887,215,993.12</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>891,787,060.17</u>	<u>887,215,993.12</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	891,787,060.17	887,215,993.12
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	580043180.00	580043180.00
51101	Өмч: - төрийн	580043180.00	580043180.00
512	Хуримтлагдсан үр дүн	(4,870,050.71)	(9,441,117.76)
51210	Өмнөх үеийн үр дүн	-4870050.71	-4870050.71
51220	Тайлант үеийн үр дүн	-	(4,571,067.05)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	316613930.88	316613930.88
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>891,787,060.17</u>	<u>887,215,993.12</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	557,601,040.00	566,999,424.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,532,440.00	155,524.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,532,440.00	155,524.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,532,440.00	155,524.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,532,440.00	155,524.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	554,068,600.00	566,843,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	510,591,200.00	526,191,500.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	40,000,000.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	470,591,200.00	526,191,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	205,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	205,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	43,477,400.00	40,447,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	43,477,400.00	40,447,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	539,804,548.31	571,570,491.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	539,804,548.31	571,570,491.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	538,253,248.31	550,507,141.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	373,803,700.00	402,169,800.00
210101	Үндсэн цалин	344,609,800.00	367,403,600.00
210104	Урамшуулал	29,193,900.00	30,521,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	4,245,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,456,100.00	54,293,000.00
210201	Тэтгэврийн даатгал	35,506,100.00	38,206,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,737,500.00	4,021,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,990,100.00	3,217,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	747,400.00	804,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,475,000.00	8,043,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,053,600.00	34,097,600.00
210301	Гэрэл, цахилгаан	878,600.00	460,100.00
210302	Түлш, халаалт	37,675,000.00	33,568,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,500,000.00	69,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,935,840.00	11,111,344.00
210401	Бичиг хэрэг	825,000.00	250,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,170,000.00	832,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	400,000.00	458,000.00
210404	Ном, хэвлэл	60,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	205,000.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,480,840.00	1,170,524.00
210408	Бараа материал акталсны зардал	-	8,195,320.00
2105	Нормативт зардал	9,278,253.00	29,117,989.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	265,000.00	111,600.00
210502	Хоол, хүнс	37,975,553.00	28,241,389.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,037,700.00	765,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	210,000.00
210604	Урсгал засвар	-	210,000.00
2107	Томилолт, зочны зардал	140,000.00	558,000.00
210702	Дотоод албан томилолт	140,000.00	558,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	48,300.00	459,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	48,300.00	209,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	250,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,537,455.31	18,490,108.05
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,574,500.00	2,070,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	28,962,955.31	16,419,608.05
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,551,300.00	21,063,350.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,551,300.00	21,063,350.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,551,300.00	21,063,350.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>17,796,491.69</u>	<u>(4,571,067.05)</u>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	(31,921,524.76)	-
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	(31,921,524.76)	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(31,921,524.76)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(14,125,033.07)</u>	<u>(4,571,067.05)</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл				0.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
C07	Тайлант үеийн үр дүн	864,735,586.12	31,921,524.76	4,870,050.71	891,787,060.17
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	864,735,586.12	31,921,524.76	4,870,050.71	891,787,060.17
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	864,735,586.12	31,921,524.76	4,870,050.71	891,787,060.17
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	864,735,586.12	31,921,524.76	4,870,050.71	891,787,060.17
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайлант үеийн үр дүн			4,571,067.05	4,571,067.05
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	864,735,586.12	31,921,524.76	9,441,117.76	887,215,993.12

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>514,068,600.00</u>	<u>566,843,900.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	514,068,600.00	566,843,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	470,591,200.00	526,191,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	470,591,200.00	526,191,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	205,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		205,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	43,477,400.00	40,447,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	43,477,400.00	40,447,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>512,868,600.00</u>	<u>565,250,800.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	512,868,600.00	565,250,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	511,317,300.00	544,187,450.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	373,803,700.00	402,169,800.00
210101	Үндсэн цалин	344,609,800.00	367,403,600.00
210104	Урамшуулал	29,193,900.00	30,521,000.00
210105	Гэрээт ажлын хөлс		4,245,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,456,100.00	54,293,000.00
210201	Тэтгэврийн даатгал	35,506,100.00	38,206,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,737,500.00	4,021,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,990,100.00	3,217,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	747,400.00	804,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,475,000.00	8,043,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,882,600.00	38,737,400.00
210301	Гэрэл, цахилгаан	878,600.00	460,100.00
210302	Түлш, халаалт	40,504,000.00	37,264,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,500,000.00	1,013,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,390,700.00	2,715,700.00
210401	Бичиг хэрэг	825,000.00	558,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,170,000.00	832,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	400,000.00	458,000.00
210404	Ном, хэвлэл	60,000.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		205,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,935,700.00	662,200.00

2105	Нормативт зардал	38,021,400.00	27,951,750.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	265,000.00	111,600.00
210502	Хоол, хүнс	36,364,500.00	27,075,150.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,391,900.00	765,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	15,210,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		15,000,000.00
210604	Урсгал засвар		210,000.00
2107	Томилолт, зочны зардал	140,000.00	558,000.00
210702	Дотоод албан томилолт	140,000.00	558,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	48,300.00	459,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	48,300.00	209,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		250,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,574,500.00	2,092,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,574,500.00	2,092,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,551,300.00	21,063,350.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,551,300.00	21,063,350.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,551,300.00	21,063,350.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>1,200,000.00</u>	<u>1,593,100.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,200,000.00	1,593,100.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,200,000.00	1,593,100.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,200,000.00	1,593,100.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,200,000.00	1,593,100.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(1,200,000.00)</u>	<u>(1,593,100.00)</u>

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	515,805,500.00	514,895,900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	515,805,500.00	514,895,900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	515,805,500.00	514,895,900.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	374,253,100.00	373,803,700.00
210101	Үндсэн цалин	345,059,200.00	344,609,800.00
210104	Урамшуулал	29,193,900.00	29,193,900.00
210105	Гэрээт ажлын хөлс		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,726,700.00	50,456,100.00
210201	Тэтгэврийн даатгал	35,696,600.00	35,506,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,757,500.00	3,737,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,006,000.00	2,990,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	751,500.00	747,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,515,100.00	7,475,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,477,400.00	45,261,200.00
210301	Гэрэл, цахилгаан	1,473,400.00	878,600.00
210302	Түлш, халаалт	40,504,000.00	42,882,600.00
210303	Цэвэр, бохир ус	1,500,000.00	1,500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,005,400.00	4,390,700.00
210401	Бичиг хэрэг	837,000.00	825,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,665,000.00	1,170,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	450,000.00	400,000.00
210404	Ном, хэвлэл	100,400.00	60,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,953,000.00	1,935,700.00
2105	Нормативт зардал	38,038,500.00	38,021,400.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	279,000.00	265,000.00
210502	Хоол, хүнс	36,364,500.00	36,364,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,395,000.00	1,391,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	210,000.00	-
210601	Багаж, техник, хэрэгсэл		
210604	Урсгал засвар	210,000.00	
2107	Томилолт, зочны зардал	669,600.00	140,000.00

210702	Дотоод албан томилолт	669,600.00	140,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	634,800.00	48,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	334,800.00	48,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,790,000.00	2,774,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,790,000.00	2,774,500.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	515,805,500.00	512,517,300.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	472,118,100.00	469,634,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	472,118,100.00	469,634,700.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	43,687,400.00	42,882,600.00
132001	Орон нутгийн төсвөөс	43,687,400.00	42,882,600.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	38.00	38.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	22.00	22.00
620003	Үйлчлэх ажилтан	14.00	14.00
620004	Гэрээт ажилтан	1.00	1.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	25.00	250.00
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	25.00	250.00
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	25.00	250.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	38.00	38.00
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	23.00	23.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	14.00	14.00
650010	Гэрээт ажилтан	1.00	1.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	205,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	205,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	205,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	205,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		205,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	205,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	205,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		205,000.00

3.Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дэлүүн сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн Аудитын газрын “Уужим алтай Аудит” ХХК-ны аудитор Х.Айгерим гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Д.Назгүл, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Дэлүүн сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2021оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго нь сургуулийн өмнөх насны хүүхэдэд цогц хүмүүжил сургалт явуулах, тэдний авьяас чадварыг нээн илрүүлж, насанд хүрэгчдийн дэмжлэгтэйгээр бие даасан байдлыг хангах боломжийг бүрдүүлэхэд оршино.

Тус цэцэрлэг нь цэцэрлэгийн сургалтын хөтөлбөрийг цэцэрлэгийн түвшинд хэрэгжүүлэх, хүүхдийн нас хөгжлийн онцлогт нийцсэн сургалт үйл ажиллагаа явуулах, бага насны хүүхдийг хөгжүүлэх, хамгаалах үйл ажиллагаанд багш, эцэг эх асран хамгаалагчын оролцоог нэмэгдүүлэх зорилт дэвшүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь аймгийн Төсвийн ерөнхийлөгчийн дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2021 онд Дэлүүн сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2019,2020 оны санхүүгийн үйл ажиллагааг хамруулж шалгасан байна.

Цэцэрлэг нь дотоод хяналтын нэгжтэй ба эрхлэгчийн тушаалаар батлагдсан журам, зааврын дагуу төлөвлөгөөт дотоод хяналтыг хэрэгжүүлдэг байна. Тус цэцэрлэгийн дотоод хяналтын талаар ойлголт олж авснаар аудитад туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дэлүүн сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 539.8 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 8.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 5.7 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Дэлүүн сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4.6 сая төгрөгөөр буюу 0.5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага		15000.0	15000.0
Урьдчилгаа			
Бараа материал	67853.7	63109.2	-4744.5
Үндсэн хөрөнгө	823933.3	809106.8	-14826.5
Нийт хөрөнгө	891787.1	887216.0	-4571.1
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	891787.1	887216.0	-4571.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	891787.1	887216	4571.1

Мөнгөн хөрөнгө, урьдчилгаа, өр төлбөрийн данс оны эхэнд болон эцэст үлдэгдэлгүй байна.

Авлага дансны үлдэгдэл 15.0 сая төгрөг болж нэмэгдсэн нь аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/1075 дугаартай захирамжаар сургууль, цэцэрлэгүүдийн төсвийн хэмнэлтээс төсөвт хийсэн зохицуулалтаар “Багшийн хөгжлийн танхим” ажиллуулахад зориулж тоног төхөөрөмж, техник хэрэгсэл худалдан авахад гэрээний дагуу шилжүүлж авлага үүсгэсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 63.1 сая төгрөг болж 4.7 сая төгрөгөөр буурсан бусад хангамжийн материалын зардлын дүн буурснаас шалтгаалжээ.

Төсвийн хөрөнгөөр 43.6 сая төгрөгийн бараа материал худалдан авч, 40.3 төгрөгийн бараа материалыг зарцуулж, бусад хангамжийн материал дансанд бүртгэлтэй байсан 8.2 сая төгрөгийн бараа материалыг сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 45 дугаар тогтоолын дагуу акталсан байна.

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн хуралдааны 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 45 дугаар тогтоолоор 8.2 сая төгрөгийн бараа материалын акталж данснаас хассан байна. Цэцэрлэгийн эрхлэгчийн тушаалаар акталсан бараа материалыг өмч хамгаалах байнгын зөвлөлийн комиссын гишүүд устгаж, акт үйлдсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 809.1 сая төгрөг болж 14.8 сая төгрөгөөр буурсан нь 1.6 сая төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр худалдан авч, 16.4 сая төгрөгийн элэгдэл байгуулснаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4.6 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн -4.6 сая төгрөг гарсантай холбоотой байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 567.0 сая төгрөг болж өмнөх оноос 9.4 сая төгрөгөөр буюу 1.7 хувиар өссөн дүнтэй байна. Өмнөх оноос материаллаг өөрчлөлт гарсан урсгал санхүүжилтийн орлого байна.

Нийт зардал 571.6 сая төгрөг болж өмнөх оноос 31.8 сая төгрөгөөр буюу 5.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэл, бараа үйлчилгээний бусад зардал, урсгал шилжүүлэг зэрэг зардлууд байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Дэлүүн сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны анх батлагдсан төсөв 602.3 сая төгрөг, тодотгосон төсөв 566.6 сая төгрөг байна.

Тодотгосон төсөв нь анх батлагдсан төсвөөсөө 35.6 сая төгрөгөөр буурсан дүнтэй байна. Үүнд: Цалингийн зардлыг 3.7 сая, нормативт зардлыг 46.5 сая төгрөгөөр бууруулж, багаж техник, хэрэгслийн зардлыг 15 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна.

Ковид-19 өвчний улмаас 2021 онд сургууль, цэцэрлэгүүдийн үйл ажиллагаанд тогтоогдсон хязгаарлалтын улмаас тус цэцэрлэгийн хоолны зардал төлөвлөснөөс 50 хувиар бага гүйцэтгэлтэй гарсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхэд 566.6 сая төгрөгийн төсөв батлагдсан байна. Нийт зарлагын 469.6 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 42.9 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 469.6 сая, орон нутгийн төсвөөс 42.9 сая, нийт 566.6 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 545.6 сая төгрөгийг зарцуулж, 21.1 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 545.6 сая төгрөг буюу 96.3 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар дээд шатны байгууллагаас нийт 0.2 сая төгрөгийн санхүүжилтийг хүлээн авч, хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал зардалд 0.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Дэлүүн сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн үйл ажиллагааны тасралт буюу Ковид цар тахлын өвчний улмаас 2021 оны санхүүгийн тайлантай холбоотой 15,0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг хил, гаалийн хаалттай байдал болон бэлтгэн нийлүүлэгчийн асуудлаас шалтгаалан тайлант онд худалдан авалт хийж чадаагүй боловч санхүүгийн тайланд тусгасан асуудал гарсан. Аудитын явцад үүнийг цаг үеийн асуудалтай хамааруулан үзэж, авлагын үлдэгдэлд тусгасан байна.

3.8 Аудитын гол асуудал

Дэлүүн сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайланд нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Дэлүүн сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэг нь 2021 онд шилэн дансанд оруулбал зохих нийт 151 мэдээллийн 148 мэдээллийг хугацаандаа оруулсан, 2 мэдээллийн оруулах хугацаа болоогүй ба 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Тус байгууллагын шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- ✓ Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш орлогын 12 гүйлгээнээс 35.9 сая төгрөгийн дүн бүхий 1 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн.
- ✓ Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш зарлагын 34.6 сая төгрөгийн 4 гүйлгээг мэдээлээгүй байна.
- ✓ Авлага үүсгэсэн талаарх 15.0 сая төгрөгийн 1 мэдээллийг оруулаагүй байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитын дүнгээр 85.4 сая төгрөгийн зөвлөмж өглөө.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримт баталж мөрдөж ажиллах, шилэн дансанд төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан аливаа шийдвэрийг мэдээлэх талаар 2 зөвлөмж, Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлтгүйгээр

чанар байдлаа алдсан 4.8 сая төгрөгийн хүнсний материалыг акталж устгасан, 67.9 сая төгрөгийн бараа материалын үлдэгдлийн тооллого хийгээгүй, үлдэгдлийг баталгаажуулаагүй зөрчилд албан шаардлага өгөгджээ.

Дэлүүн сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 1/5 дугаартай албан бичгээр зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг ирүүлсэн байна.

Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмж, албан шаардлагын мөрөөр хийсэн ажлын тайланг шилэн дансанд байршуулаагүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн санхүүгийн тайлангийн аудитаар тус хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн ажил, гүйлгээний анхан шатны баримтын бүрдэл, зардлын дансны бичилт, нярвын бараа материалын тайлангийн бүрдүүлэлт болон төсвийн хөрөнгөөр худалдан авсан бараа материалын зарцуулалтад хяналт тавих, эд хөрөнгийн тооллогын тооцоо бодолтод анхаарах шаардлагатай.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 94.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 0.2 сая төгрөгийн алдааг залруулж, 0.6 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1.2 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлж, 92.0 сая төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Төсвийн гүйцэтгэлийн тайланд төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг 0.2 сая төгрөгөөр илүү тайлагнасан алдааг залруулсан.

4.2 Төлбөрийн акт

Цэцэрлэгийн эрхлэгч Х.Амангүлд 0.4 сая, нягтлан бодогч Ж.Лидад 0.2 сая төгрөгийн цалин, урамшууллыг илүү олгосон нийт 0.6 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

Шийдвэрлэсэн нь: Илүү тооцож олгосон цалин, нэмэгдэл, урамшуулал болох 0.6 сая төгрөгийг хавсралтад заасан нэр бүхий хүмүүсээр төсөвт нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

1. Дэлүүн сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэг нь тайлант онд Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд тэвчиж болох зардлын 10 хувь 2727.4 мянган төгрөгийн **1227.4** мянган төгрөгт нь хэмнэлт тооцож, урсгал зардлыг төлөвлөн зарцуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 41 дүгээр зүйлийн 41.2.3, Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1 дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хууль, Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлж төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах албан шаардлага өгөв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Санхүүгийн анхан шатны баримтын бүрдүүлэлт, нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлагналтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тээвэр, шатахуун, шуудан холбоо интернетийн төлбөр, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх, гэрэл цахилгаан, цэвэр бохир ус, нормын хувцас, зөөлөн эдлэл, бага үнэтэй түргэн элэгдэх зардлын төсвөөс худалдан авсан нийт 3.6 сая төгрөгийн зардлыг тооцооны дансаар дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан, анхан шатны бүрдэл дутуу баримтаар 1.5 сая төгрөгийн ажил гүйлгээг зардлаар хүлээн бүртгэсэн, няравын бараа материалын тайлангийн орлого, зарлагын анхан шатны баримтууд дутуу, бараа материалын үлдэгдлийг санхүүгийн тайлангийн үлдэгдлээс 1.5 сая төгрөгөөр зөрүүтэй гаргасан байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 13.7, 14 дүгээр зүйлийн 14.3, 14.3.2, 14.3.3, 14.4, 14.4.1 14.4, 14.4.5, 20.2, 20.2.5, 20.2.6 дахь заалтуудыг мөрдөж худалдан авсан бараа материалыг шууд зардлаар бүртгэж тайлагнасан зөрчлийг арилгах, санхүүгийн анхан шатны баримтын бүрдүүлэлтийг хангаж ажиллах, Сангийн сайдын 2010 оны 388 дугаар тушаалаар баталсан Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланг бэлтгэх аргачлал, зааврыг мөрдөж ажиллах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын газарт 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	/сая төгрөгөөр/									
		Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
		Тоо	Дүн	Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Дэлүүн сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэг	7	94.0	1	0.2	1	0.6	1	1.2	4	92.0